



НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 12 өдөр

Дугаар 4/93

Улаанбаатар хот

“Улаанбаатар Марафон 2022”-д оролцогчдод эрүүл
мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.4 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Улаанбаатар марафон олон улсын гүйлт зохион байгуулах тухай” А/546 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар марафон 2022” олон улсын гүйлтийн үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, зохион байгуулах удирдамжийг хоёрдугаар, эрүүл мэндийн үзлэгийн хуудсыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Марафон гүйлтийн үед үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангаж, чанарын өндөр түвшинд зохион байгуулахыг Ажлын хэсэг (Б.Нинж)-т үүрэг болгосугай.

3. Гүйлтийн гараа, бариа болон гүйлтийн зам дагуух яаралтай тусламжийн цэгт удирдамжийн дагуу эмч, эмнэлгийн мэргэжилтэнг томилж, эм, эмнэлгийн хэрэгслээр бүрэн хангаж, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг харьяа байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж, үйлчилгээ хариуцсан Орлогч дарга (Л.Зэндмаа)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.БЯМБАДОРЖ



1150500182

**“УЛААНБААТАР МАРАФОН 2022” ОЛОН УЛСЫН ГҮЙЛТИЙН ҮЕИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч:

	Б.Нинж	Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга.
Гишүүд:	Д.Энхтүвшин	Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн;
	Н.Болдбаатар	Уламжлалт, сэргээн засах, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусламж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн;
	С.Ариунболд	Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн дарга;
	З.Балдандугар	Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төвийн дарга;
	М.Болд	Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн дарга;
	П.Бат-Ирээдүй	Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвийн дарга;
	Ц.Лхагва	Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төвийн дарга;
	Э.Бодьцэцэг	Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төвийн дарга;
	Ө.Туул	Баянзүрх нэгдсэн эмнэлгийн гүйцэтгэх захирал;
	М.Чимгээ	Сүхбаатар дүүргийн нэгдсэн эмнэлгийн дарга;
	Т.Энхзаяа	Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлгийн дарга;
	Х.Амартүвшин	АШУҮИС-ийн Их сургуулийн эмнэлгийн хөгжлийн газрын дарга /зөвшилцсөнөөр/.

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2022 оны 05 дугаар сарын 12 ны өдрийн
А93 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



“УЛААНБААТАР МАРАФОН 2022” ОЛОН УЛСЫН ГҮЙЛТИЙН ҮЕИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

Зорилго:

“Улаанбаатар марафон 2022” олон улсын гүйлтийн үед эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чанартай, хүртээмжтэй, шуурхай үзүүлэх.

Хамрах хүрээ:

Нийслэлийн Эрүүл мэндийн газар, харьяа эрүүл мэндийн байгууллага, Өрхийн эрүүл мэндийн төв, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. Харьяа эрүүл мэндийн байгууллагууд “Улаанбаатар марафон-2022” гүйлтэд оролцохоор бүртгүүлсэн гадаад, дотоодын иргэдэд эрүүл мэндийн үзлэг хийх, дүгнэлт гаргах,
2. Марафон гүйлтийн үед үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чанарын өндөр түвшинд зохион байгуулах,
3. Гүйлтийн замд хуваарьт байгууллагууд яаралтай тусламжийн цэгийг байгуулан, бэлэн байдлыг хангаж, хяналт тавьж ажиллах,
4. Яаралтай тусламжийн цэгүүдэд гуравдугаар хүснэгтэд заасан тоног төхөөрөмж, багаж, эм, эмнэлгийн хэрэгслийг бүрэн байрлуулж, мэс засал, гэмтэл, зүрх судас, сэргээн засах, яаралтай тусламжийн мэргэжлийн эмч, сувилагч нарыг томилж, ажиллуулах,
5. Эмнэлгийн тусламж үйлчилгээ авах шаардлагатай хүмүүст газар дээр нь болон тээвэрлэлтийн явцад эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх, лавлагаа шатлалын болон төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт хүргэх үүрэг бүхий түргэн тусламжийн 3 багийг хоёрдугаар хүснэгтэд заасан хуваарийн дагуу ажиллуулах,
6. Марафон гүйлтийн үеийн болзошгүй эрсдэлээс сэргийлж, дүүргийн Нэгдсэн эмнэлэг, хэвтүүлэн эмчлэх тусламж үзүүлдэг Эрүүл мэндийн төвүүд яаралтай тусламжийн тасгийн бэлэн байдлыг хангаж, шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх,
7. Нийслэлийн Түргэн тусламжийн төв шаардлагатай тохиолдолд нэмэлтээр ажиллах түргэн тусламжийн багийг томилох, бэлэн байдлыг хангаж ажиллах.

Тусламж, үйлчилгээ үзүүлэх хуваарь:

НЭГ. ГҮЙЛТЭНД ОРОЛЦОГЧДЫГ ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗЛЭГТ ХАМРУУЛАХ

№	Эрүүл мэндийн үзлэг	Үйлчилгээ үзүүлэх байгууллага	Хяналт тавих албан тушаалтан
1	Оролцогчдод гүйлтийн тэмцээн товлөгдсөн өдрөөс өмнө эрүүл мэндийн үзлэг хийх	Тухайн хорооны Өрхийн эрүүл мэндийн төвүүд	ДЭМТ-ийн нийгмийн эрүүл мэндийн орлогч дарга нар
2	Гарааны талбайд эрүүл мэндийн үзлэг хийх	БЗЭМТ, ЧЭМТ	Эрүүл мэндийн төвийн дарга нар

ХОЁР. ГҮЙЛТИЙН ҮЕД ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ

№	Үйлчлэх чиглэл	Цэгийн байршил	Ажиллах байгууллага	Цэгт ажиллах багийн ахлагч	Хяналт тавих албан тушаалтан
1	Яаралтай тусламжийн 1-р цэг	45-р сургуулийн өмнөх талбайд	ХУНЭ, ХУЭМТ	Д.Мажигсүрэн, ХУНЭ-ийн ЭЭО дарга	Н.Болдбаатар, ЭТХ-ийн мэргэжилтэн
2	Яаралтай тусламжийн 2-р цэг	Модерн номадсын урд талбайд	БГЭМТ, СБЭМТ	Э.Идэр, БГЭМТ-ийн ЭЭО дарга	Р.Октябрь, ЭТХ-ийн мэргэжилтэн
3	Яаралтай тусламжийн 3-р цэг	Е-март худалдааны төвийн уулзварын хойно	БЗНЭ, СБНЭ	Ө.Айгиймаа, БЗНЭ-ийн ерөнхий эмч	Э.Энхзаяа, ЭТХ-ийн мэргэжилтэн
4	Яаралтай тусламжийн 4-р цэг	СЭЗИС-ийн замын өмнөх талбайд	АШУУИС	Д.Дашбазар, МЯЭ-ийн ЯТТ-ийн эрхлэгч	Э.Эсү, ЭТХ-ийн мэргэжилтэн
5	Яаралтай тусламжийн 5-р цэг	Сүхбаатарын талбайд, гараа барианы цэгт	БЗЭМТ, ЧЭМТ	Ш.Мөнхцэцэг, БЗЭМТ-ийн ЭЭО дарга	Б.Нинж, ЭТХ-ийн дарга
6	Түргэн тусламжийн 1-р баг	Сүхбаатарын талбайд, гараа барианы цэгт	НТТ-ийн төв	Б.Айболат, НТТТ-ийн орлогч дарга	Д.Энхтүвшин, ЭТХ-ийн мэргэжилтэн
7	Түргэн тусламжийн 2-р баг	Гүйлтийн зам дагуу /яаралтай тусламжийн 1,2-р цэгийн дунд/	НТТ-ийн төв		
8	Түргэн тусламжийн 3-р баг	Гүйлтийн зам дагуу /яаралтай тусламжийн 3,4-р цэгийн дунд/	НТТ-ийн төв		

**ГУРАВ. ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН ЦЭГТ ШААРДЛАГАТАЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ,
БАГАЖ, ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ**

Шаардлагатай эм, бэлдмэл				
№	Эмийн олон улсын буюу ерөнхий нэршил	Тун хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Адреналин гидрохлорид	0.1%-1мл	ам	4
2	Атропин сульфат	0.1%-1мл	ам	4
3	Кофейн бензоат натри	20%-1мл	ам	4
4	Кордиамин	25%-1мл	ам	4
5	Дигоксин	0.025%-1мл	ам	4
6	Дексаметазон	4мг-1мл	ам	4
7	Эуфиллин	2.4%-10мл	ам	6
8	Димедрол /дифенгидрамин/	1%-1мл	ам	6
9	Анальгин	50%-2мл	ам	6
10	Магни сульфат	25%-10мл	ам	8
11	Кальци глюконат	10%-10мл	ам	2
12	Морфин гидрохлорид	1%-1мл	ам	4
13	Диклофенак натрия	50мг-3мл	ам	2
14	Трамадол	100мг-2мл	ам	6
15	Лидокайн гидрохлорид	2%-2мл	ам	6
16	Новокайн	25%-2мл	ам	20
17	Седуксин /Апаурин/	10мг-2мл	ам	4
18	Аминазин /хлорпромазин/	2.5%-2мл	ам	2
19	Дроперидол	2.5мг/мл	фл	1
20	Дибазол	1%-2мл	ам	4
21	Фуросемид	1%-2мл	ам	2
22	Прозерин	0.05-%1мл	ам	1
23	Аминокапроны хүчил	40%-10мл	ам	6
24	Метоклопрамид	10мг-2мл	ам	2
25	Ношпа /дротаверин/	2%-2мл	ам	4
26	Натри хлорид	0.9%-500мл	фл	3
27	Натри хлорид	0.9%-250мл	фл	3
28	Натри хлорид	0.9%-2мл	ам	10
29	Рингенийн уусмал	500мл	фл	2
30	Глюкоз	40%-10мл	ам	5
31	Витамин С	5%-2мл	ам	6
32	Нитроглицерин /цацлага/	0.5мг	фл	1
33	Валидол	0,06гр	шах	1
34	Каптоприл	25мг	шах	10
35	Атенолол	5мг	шах	10
36	Энап Р	12,5мг	ам	2
37	Аспирин	500мг	шах	10
38	Парацетамол	500 мг	шах	10
39	Сальбутамол цацлага		фл	1
40	Өвдөлт намдаагч цацлага		фл	3
41	Тамедин /багстай/	5%-50мл	фл	3
42	Санитол	70%-50мл		

43	Эмнэлгийн вазелин	20 гр	тюб	1
44	Хросол /Уулгаж сэлбэх олон найрлагат давсны уусмал/	27.9 гр	ш	10
Боолтын материал				
1	Уян боолт	15см*4.5м	ш	10
2	Уян боолт	7.5см*4.5м	ш	10
3	Бинт	14см*7м	ш	2
4	Хөвөн	50гр	ш	3
5	Шархны ариун наалт		ш	10
6	Самбай, сальфетка /ариун/		ш	50
6	Хурууны лент		ш	100
7	Пластырь		ш	2
8	Гурвалжин алчуур		ш	2
Нэг удаагийн эмнэлгийн хэрэгсэл				
1	Үзлэгийн бээлий	Хангалттай хэмжээгээр		
2	Тариур 3гр		ш	5
3	Тариур 5гр		ш	5
4	Тариур 10гр		ш	5
5	Тариур 20гр		ш	2
6	Дуслын систем		ш	5
7	Уян зүү 16-24G		ш	5
8	Уян зүүний наалт		ш	5
9	Хүчилтөрөгчийн маск /том хүн/		ш	2
10	Хүчилтөрөгчийн маск /хүүхэд/		ш	1
11	Хамрын гуурс /том хүн/		ш	2
12	Хамрын гуурс /хүүхэд/		ш	1
13	Хос замт амьсгалын гуурс /ком/		ш	1
14	Нэг удаагийн хэл дарагч		ш	10
Багаж, тоног төхөөрөмж				
1	Чагнуур	Эмч бүрийн тоогоор		
2	Даралтын аппарат	Эмч бүрийн тоогоор		
3	Пульсоксиметр	Эмч, сувилагч бүрийн тоогоор		
4	Глюкомер	1 ш		
5	Зайнаас халуун хэмжигч	1 ш		
6	Зүрхний бичлэгийн аппарат	1 ш		
7	Дефибрилятор	1 ш		
8	Мөсөн жин	Хангалттай хэмжээгээр		
9	Мөчдийн чиг	2 ком		
10	Жижиг мэс ажилбарын ком /оёдол тавих, цус тогтоох, шарх цэгцлэх/	1 ком		
11	Дулаан хөнжил	2 ш		
12	Хүчилтөрөгчийн зөөврийн баллон /5-10литр/ урсгал тохируулагчтай	2 ш		
13	Дамнуурга	2 ш		
14	Тэргэнцэр	2 ш		

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн
493 дугаар тушаалын гуравдугаар хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗЛЭГИЙН ХУУДАС

Овог, нэр:

Нас: Хүйс: Биеийн жин:

Одоогийн зовиур:

Сүүлийн 7 хоногийн дотор архи, согтууруулах ундаа хэрэглэсэн эсэх:

Тамхи татдаг эсэх /доогуур зурах/: Тийм/ Үгүй

Урьд нь өвчилж байсан өвчин, эмгэг:

- | | |
|------------------------------|-----------------------------------|
| 1. Цусны даралт ихсэх өвчин | Тийм/ Үгүй |
| 2. Зүрхний цус хомсрох өвчин | Тийм/ Үгүй |
| 3. Цусны эргэлтийн дутагдал | Тийм/ Үгүй |
| 4. Уушгины багтраа | Тийм/ Үгүй |
| 5. Коронавируст халдвар | Тийм/ Үгүй Батлагдсан огноо:..... |

Сүүлийн 7 хоногт доорх зовиур илэрсэн эсэх:

Халуурах ☐ Бөөлжих ☐ Суулгах ☐ Цээжээр хөндүүрлэх ☐

Үзлэгт:

Артерийн даралт: Баруун/....., Зүүн/.....,

Судасны цохилт 1 минутад: Тайван үед, Ачаалалтай үед

Дүгнэлт: Гүйлтэд оролцож болно ☐ Гүйлтэд оролцож болохгүй ☐

Гүйлтэд оролцох боломжгүй иргэнд дараах зөвлөмжийг өгөв:

Гүйлтэд оролцох боломжгүй тухай зөвлөмжтэй танилцсан:

Иргэн: Гарын үсэг:

Эмчийн нэр, гарын үсэг: /

Тамга

20..... оны сарын өдөр